

ХАР ТАМХИ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨЛӨХ ЭМ БЭЛДМЭЛИЙН ГААЛИЙН ХЯНАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АРГА ЗАМ

Н.Мөнхзул*, Н.Батнасан**

Хураангуй: Гаалийн байгууллагын мэдээгээр сүүлийн жилүүдэд Монгол улсын хилээр хууль бусаар нэвтрэн орсон хар тамхи тоо хэмжээ, нэр төрлийн хувьд нэмэгдсэн төдийгүй өсвөр насныхан болон залуучуудын дунд хар тамхины хэрэглээ нэмэгдэж байгаа нь цагдаагийн байгууллагын тоо баримтуудаар нотлогдож байна. Энэ нь хар тамхины хууль бус худалдаанд хяналт тавьж чадахгүй байгааг харуулж байна.

Тиймээс, олон улсын хэмжээнд үр дүнтэй ашиглаж буй туршлагад тулгуурлан хувь хүн, нийгэмд онц хор хөнөөлтэй хар тамхины хууль бус худалдаатай тэмцэх арга замыг боловсронгуй болгох, хууль хяналтын байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах зорилгоор энэхүү өгүүлийг бичив.

Түлхүүр үгс: Хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, хар тамхины нийлүүлэлт ба хэрэглээ, хил ба гаалийн хяналт, хууль хяналтын байгууллагуудын үйл ажиллагаа

WAYS TO IMPROVE CUSTOMS CONTROL OF NARCOTICS AND PSYCHOTROPIC DRUGS

Abstract: According to the customs agency, in recent years, the quantity and types of drugs illegally smuggled across the border of Mongolia have increased, and the data of the police show that the use of drugs among teenagers and young people is increasing. That information shows the inability to control the illegal drug trade.

Thus, the current article aims to improve the methods of combating the illegal drug trade, which is extremely harmful to individuals and society, and to improve the coordination of the activities of domestic law enforcement agencies based on efficient international experiences.

Keywords: narcotics and psychotropic drugs, border and customs control, supply and use of narcotics, activities of law enforcement agencies

* МУИС, Бизнесийн сургууль, (E-mail): zulaa_g16@yahoo.com

** МУИС, Бизнесийн сургууль, (E-mail): batnasan@num.edu.mn

Хар тамхинд донтох нь хувь хүний эмгэгт тооцогдох боловч энэ нь нийгэмд тархсан нэгэн төрлийн тахал юм. Хар тамхи хэрэглэсэн хүн эрүүлээр сэтгэх чадвараа алдаж, гэмт хэрэг үйлдэх буюу гэмт хэргийн золиос болох нь олонтаа. Хар тамхинд орсон хүн түүнийг олж хэрэглэхийн тулд юугаа ч золиослоход бэлэн байдалд хүрэх ба хар тамхи худалдан авах мөнгө олохын тулд хулгай дээрэм, хүчирхийллийн гэмт хэрэгт холбогдох нь элбэг. Хар тамхины тунг хэтрүүлэн хэрэглэсний улмаас жил бүр олон мянган хүн амь насаа алддаг. АНУ-ын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн мэдээгээр сүүлийн жилүүдэд тус улсад жил бүр бараг 100.0 орчим мянган хүн амь насаа алдаж байна. Хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл хэтрүүлэн хэрэглэсний улмаас амь насаа алдсан хүний 100000 мянган хүн ам тутамд ногдох тоо 21.6-д хүрсэн. Энэ нь 1990-ээд оны сүүл үеэс бараг 8 дахин өссөн үзүүлэлт юм. (Төрийн департамент, 2023)

Дэлхий дахиныг хамарсан даяаршлын нөлөөгөөр хар тамхины хэрэглээ жилээс жилд өсөх хандлагатай болж, хэрэглээ нь түүхэн дээд хэмжээндээ хүрсэн төдийгүй түүнийг хэрэглэгчдийн нас улам бүр залуужих хандлагатай болсон нь анхаарал татах асуудал болоод байна. Хувь хүнийхээ хувьд бүрэн төлөвшиж чадаагүй өсвөр насныхны дунд хар тамхины хэрэглээ нэмэгдэх хандлагатай болсон төдийгүй хар тамхийг дагалдсан хэрэг зөрчил, хүчирхийллийн тоо жилээс жилд өсч байгаа нь хар тамхи нийгмийг хамарсан хар тахал болох аюулын харангыг дэлдэж буй хэрэг юм.

Сүүлийн жилүүдэд хар тамхины хэрэглээ ихтэй Зүүн өмнөд Ази, Төв Азийн орнуудаас төдийгүй хөрш орнуудаас нийлэгжүүлэх аргаар гарган авсан сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, хар тамхийг улсын хилээр нэвтрүүлсэн, нэвтрүүлэхийг завдсан, зарж борлуулсан, хэрэглэсэн хэрэг зөрчлийн тоо ихсэх болсон. Үүнээс улбаатайгаар НҮБ-аас жил бүр гаргадаг дэлхийн хар тамхитай тэмцэх илтгэлд 2010 онд дамжин өнгөрүүлэгч орон гэж тэмдэглэгдэж байсан Монгол улс 2016 оноос хэрэглэгч улс болон дурдагдах болсон. (Норвегийн нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн, 2023)


Хувь хүний болон нийгмийн аюулгүй байдал, хүний эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгө, ажил эрхлэлт, амьдралын чанарт хор хөнөөлтэй тул хар тамхины хууль бус худалдааг таслан зогсоох нь төрийн байгууллагын үйл ажиллагааны чухал зорилтуудын нэг юм.

Өнөөгийн нөхцөл байдалд хийсэн шинжилгээ

Хар тамхи болон, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн талаар Гаалийн ерөнхий газрын Гаалийн зөрчилтэй тэмцэх, хэрэг бүртгэх газраас “Мансууруулах эм,

сэтгэцэд нөлөөлөх бодис улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэргийн нөхцөл байдал, чиг хандлага, тулгамдсан асуудлууд” сэдвээр жилдээ нэг удаа албан ёсны мэдээ тайланг гаргадаг. Үүнээс өөрөөр энэ асуудлыг судалсан албан ёсны судалгаа тайлан сүүлийн 10 гаруй жилийн дотор хийгдээгүй юм.

Зураг 1. Монгол улсын хилээр хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийг хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэргийн тоо үзүүлэлт



Эх сурвалж: Монгол улсын гаалийн ерөнхий газрын мэдээлэл

Тус газраас гаргасан улсын хилээр хар тамхи болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэргийн тоо баримтад тулгуурлан хар тамхи ба сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн нөхцөл байдал, түүнд гарч буй өөрчлөлтийн талаар төсөөлөл авах боломжтой юм.


Тухайлбал, гаалийн ажилтнууд 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд нийт 22 удаагийн үйлдлээр 2306 мл, 1303.39 гр, 83 ширхэг мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг улсын хилээр нэвтрүүлэх оролдлогыг илрүүлсэн. Хамгийн сүүлийн мэдээгээр 2022 оны 9 сараас хойш богинохон хугацаанд нийт 16 үйлдлээр Пинака /синтетик бодис/ 1670 мл, Экстази /MDMA Ecstasy/, ЛСД /LCD/ 83 ширхэг, Delta-9 THC vape 66 мл, Шаттер /shatter delta-9 THC/ 40 гр, Delta-8 THC агуулсан зөөлөн чихэр 234 гр, Амфетамин 40 гр нэвтрүүлэх гэсэн оролдлогуудыг таслан зогсоосон. (ГЕГ, Гаалийн зөрчилтэй тэмцэх, хэрэг бүртгэх газрын тайлан, 2010-2022)

2010-2018 оны хооронд БНХАУ, ОХУ, Хонгконг, ХБНГУ, Нидерланд, Малайз, Англи, АНУ зэрэг орнуудаас Монгол улсын хилээр хар тамхи болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийг оруулж ирэх гэсэн оролдлогуудыг илрүүлсэн. 2020-2022 онуудад дээрх жагсаалтад Вьетнам, Австрали гэсэн хоёр орон

нэмэгдсэн.

Дээр харуулсан Зураг №1-ээс хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийг улсын хилээр нэвтрүүлэх оролдлого, нэвтрэн орж ирж буй хар тамхи ба сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн нэр төрөл хэрхэн өргөжиж буйг харах боломжтой байна. Ялангуяа сүүлийн 3 жилийн дотор хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийг улсын хилээр нэвтрүүлэх гэсэн оролдлогын тоо эрчимтэй өссөн болохыг харж болохоор байна.

Зураг 2. Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн тоо насны ангиллаар



Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газраас гаргасан мэдээлэл

Хар тамхи ба сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн нийлүүлэлт ба хэрэглээ өсөн нэмэгдэж буйг харуулах өөр нэгэн үзүүлэлт нь мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлтэй холбоотойгоор гарсан гэмт хэргийн тоо юм. Монгол улсад хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн хууль бус эргэлтийг таслан зогсоох зорилгоор байгуулсан ЦЕГ-ын Хар тамхитай тэмцэх газраас гаргасан мэдээгээр улсын хэмжээнд сүүлийн 5 жилийн хугацаанд ийм төрлийн 1296 гэмт хэрэг бүртгэгдсэний 91.4%-ийг эрэгтэйчүүд, 8.4%-ийг эмэгтэйчүүд эзэлж байна. Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 82% нь нийслэлд, 18% нь орон нутагт бүртгэгджээ. Насны ангиллаар авч үзвэл, 18-25 насныхан 54.1 хувийг, 26-35 насныхан 32.6 хувийг, 36-аас дээш насныхан 7.7 хувийг, 13-17 насныхан 5.6 хувийг тус тус эзэлж байна. Нийт үйлдсэн гэмт хэргийн 92.3%-ийг 18-35 насны залуучууд болон өсвөр насны хүүхдүүд эзэлж байгаа нь анхаарал татах үзүүлэлт мөн юм. (ЦЕГ, 2022)


Доорх зурагт (Зураг № 3) мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх

эм бэлдмэлтэй холбоотой гэмт хэрэгт холбогдсон иргэдийн ажил эрхлэлт, боловсролын байдлыг харууллаа. Гэмт хэргийн нөхцөл байдал ажил хөдөлмөр эрхэлдэггүй буюу боловсрол багатай хүмүүсийн дунд илүү өндөр хэмжээнд байгааг эндээс харах боломжтой байна.

Тухайлбал, нийт хөдөлмөрийн насны хүн амд ажилгүйчүүд сүүлийн жилүүдэд 7-8%-ийг эзэлж байгаа бол энэ төрлийн гэмт хэрэгт холбогдсон иргэдийн 57%-ийг ажилгүй хүмүүс эзэлж байна. Мөн үйлдэгдсэн гэмт хэргийн ■ хувийг дээд боловсрол эзэмшээгүй иргэд үйлджээ. Дээрх судалгаа нь залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хүүхэд залуучууд руу чиглэсэн сурталчилгааг өргөжүүлэх зэрэг нь хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээтэй тэмцэхэд чухал ач холбогдолтой болохыг харуулж байна.

Монгол улсад хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлтэй холбоотой гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдалд хийсэн шинжилгээгээр дээрх гэмт хэрэгт холбогдож буй иргэдийн нас залуужсан ба хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн хэрэглээ, нийлүүлэлт нь нэр төрлийн хувьд өсөн нэмэгдэж байгааг нь харуулж байна.

Зураг 3. Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлтэй холбоотой гэмт хэрэгт холбогдсон иргэдийн ажил эрхлэлт, боловсролын байдал



Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газрын мэдээ

Гадаад нөхцөл байдалд хийх шинжилгээ

Монгол улс нь хар тамхийг тариалагч орон биш юм. Түүнчлэн манай оронд химийн үйлдвэрлэл өндөр түвшинд хөгжөөгүй тул хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийг дотоодод үйлдвэрийн аргаар нийлэгжүүлж гарган авах

боломжгүй. Тиймээс манай оронд мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн нийлүүлэлт хийгдэх цорын ганц суваг нь хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн хууль бус импорт болно. Дээр дурдсан нөхцөл байдлаас үүдэн, Монгол улсад нүүрлээд байгаа хар тамхи ба сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн хэрэглээ ба нийлүүлэлт нь гадаад нөхцөл байдлаас шууд хамааралтай байдаг хэмээн дүгнэж болох юм.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хар тамхины гэмт хэрэгтэй тэмцэх албанаас хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийг хэрэглэсний улмаас 2020-2022 онуудад эмчлүүлсэн эмнэлэгийн үйлчлүүлэгчдийн дунд хийсэн судалгаагаар янз бүрийн бүс нутгуудад хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн хэрэглээ бүс нутаг бүрт харилцан адилгүй байжээ. Тухайлбал, Ази, Европ, Австралид опиатын хэрэглээ өндөр хэмжээнд байсан бол Өмнөд Америкт кокаиныг, Африкт каннабисыг гол төлөв хэрэглэн эмчлүүлжээ. Харин ганцхан Хойд Америкт опиад, каннабис, кокаин, амфетамин болон бусад хар тамхийг харьцангуй жигд хэмжээнд хэрэглэж байжээ.

Интерполын мэдээлснээр 2022 онд гол төлөв Өмнөд Африк, АНУ, Мексик, Баруун Европын орнуудад 6000 гаруй тонн каннабис хураан авсан нь 2020 оныхоос 20%-иар өссөн үзүүлэлт юм. (АНУ-ын Төрийн департаментын Олон улсын хар тамхины хууль сахиулах асуудал эрхэлсэн газар, 2022)

Европын орнуудад жил бүр бүр барагцаалбал 200 тн кокаин хууль бусаар хил нэвтэрдэг. 2020 онд опиумын үйлдвэрлэл ойролцоогоор 7800 тн-д хүрсэн (Европын холбоо, 2023) бөгөөд үүнийг баруун өмнөд Азийн орнуудад намуу цэцгийн тариалан өргөжиж байгаатай холбож үзэх болсон. Мансууруулах бодисын хэрэглээ дэлхий дахинд ийнхүү хурдацтай өсөх болсноор хар тамхи ба сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн хууль бус худалдааны эргэлт түргэн хурдацтай нэмэгдэж, хар тамхитай холбоотойгоор үйлдэгдэж буй гэмт хэрэг, нас баралтын тоо үлэмж хэмжээгээр өсчээ. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан тооцоогоор 2022 онд бараг хагас сая хүн нас барсан ажээ. (Норвегийн нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн, 2023)

2002 оноос хойш кокаин хэрэглээний түвшин буурч, эсвэл тогтвортой хэвээр байгаа бол марихуан, героины хэрэглээ нэмэгдэж 7,8% байна. 2022 оны байдлаар өсвөр насныхан тамхинаас илүү марихуан татдаг бөгөөд 2022 онд 156,000 хүн героин хэрэглэж эхэлсэн нь 2020 оноос хойш бараг хоёр дахин их байна. (ДГБ, 2023)

Улс орнуудын туршлага ба хар тамхитай тэмцэх арга зам

Дэлхий дахинд өргөн хэмжээгээр тархсан хар тамхитай тэмцэх зорилгоор

НҮБ-аас 1961 онд “Хар тамхи ба сэтгэцэд нөлөөлөх бодисуудад хяналт тавих асуудлаарх олон улсын конвенц”-ыг батлан гаргасан бөгөөд дээр конвенцид 1971, 1988 онуудад өөрчлөлт оруулж, уг ажлыг эрчимжүүлэх зорилгоор НҮБ-ын дэргэд Мансууруулах бодисын хяналтын олон улсын зөвлөлийг байгуулжээ. Монгол улс хар тамхитай тэмцэх зорилгоор 2003 онд энэхүү конвенцид нэгдэн орсон бөгөөд улсад хүлээсэн үүргийнхээ дагуу хар тамхитай тэмцэх чиг үүрэг бүхий төрийн тусгай албадаас гадны тусгай албадтай үйл ажиллагааг уялдуулж, хамтран ажиллаж байна.

АНУ-ын Төрийн департаментын Олон улсын хар тамхины тэмцэх асуудал эрхэлсэн газраас 2022 оны 3 дугаар сард гаргасан “Олон улсын мансууруулах бодисын хяналт стратегийн тайлан”-д НҮБ-ын дэргэдэх Мансууруулах бодисын хяналтын олон улсын зөвлөл гишүүн 197 орнуудын хар тамхины эрэлт, нийлүүлэлт, улс хоорондын хууль бус худалдааны эргэлтийн талаар 232 хуудас дэлгэрэнгүй судалгааг танилцуулсан. Гэвч энэхүү судалгааны тайланд манай улстай холбоотой ямар нэгэн мэдээлэл ороогүй.

Дээрх судалгаанд манай улсыг оруулаагүй нь хар тамхи болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн хууль бус хэрэглээтэй тэмцэх стратеги бодлого нь тодорхойгүй, тэмцэж буй арга хэлбэр нь буруу, эрэлт нийлүүлэлтийн талаар тоймтой тоон мэдээлэл цуглуулж чадаагүй зэрэгтэй холбоотой байж болох юм.

АНУ-ын Төрийн департаментгаас гаргасан дээрх тайланд тус улс дэлхийн 100 гаруй улстай хамтран ажиллаж, мэдээлэл солилцож, үйл ажиллагаандаа ашиглаж буй талаар дурджээ. Дээрх тайлангаас тамхи болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлд хяналт тавихад гадаад хамтын ажиллагаа онцгой ач холбогдолтой болохыг харж болохоор байна. Монгол улс руу хар тамхийг хууль бусаар нэвтрүүлэхийг оролдож буй оролдлого, жагсаалтад орсон улс орнуудын тоо өсөн нэмэгдэж байгаатай холбоотойгоор гадаад хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, хар тамхитай тэмцэж буй шилдэг туршлагаудыг нэвтрүүлэх хэрэгцээ шаардлага өсөн нэмэгдэж байна.

Сүүлийн жилүүдэд Норвеги, Шинэ Зеланд, Португал, Их Британи, Австрали, Канад, Гүрж, Хойд Македони, Коста Рика, Сенегал зэрэг орнууд хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн хэрэглээгээ буруулж чадсан.

Хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн хяналтыг амжилттай хэрэгжүүлж байгаа Норвеги улсын туршлагаас үзэхэд тус улс хар тамхины хууль бус импорттой тэмцэхээс гадна сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийнхээ хэрэглээнд хатуу хяналт тогтоож, хар тамхитай тоэмцэх үндэсний нэгдсэн зохицуулалтыг бий болгож, урьдчилан сэргийлэх, хар тамхинд донтсон иргэдийг эмчлэх, нийгэмшүүлэх ажилд онцгойлон анхаарч ажилласны үрээр

ийм амжилтад хүрсэн байна.

АНУ, Австрали болон бусад улс орнуудын туршлагаас үзэхэд хар тамхитай тэмцэх ажлыг нэгдсэн зохион байгуулалтад оруулах, үндэсний хэмжээнд ажиллах бүтэц зохион байгуулалт, зарцуулах зардал төсвийг бий болгох тал дээр онцгой анхаарсан байна. Мөн импорт, үйлдвэрлэл нийлүүлэлтэд хяналт тавихаас гадна албан ёсны зөвшөөрөлтэй сэтгэгцэд нөлөөлөх эм бэлдмэлийн үйлдвэрлэл, хэрэглээнд хяналт тавьж, эцсийн хэрэглэгчийг олж илрүүлсэн нөхцөлд хойноос нь мөшгөх замаар нийлүүлэгч болон сүлжээ, гэмт бүлэглэлүүдийг илрүүлэх болсон байна.

Манай улсын хувьд хар тамхитай тэмцэх асуудал ЦЕГ-ын дэргэдэх Хар тамхитай тэмцэх газар, ГЕГ зэрэг байгууллагууд хариуцдаг. Тусгайлсан төсөвгүй, эрх мэдэл багатай ийм бүтцийг ажиллуулаад үр дүнд хүрэх нь бага юм.

Манай улсын практикт хар тамхи, сэтгэгцэд нөлөөлөх эм бэлдмэлийн хууль бус эргэлттэй тэмцэх тэмцэлдээ импортод хатуу хяналт тавих, үйлдсэн гэмт хэргийн нөхцөл байдлыг хянах зэрэг асуудлыг голлон анхаарч байгаа нь ерөнхийдөө хоцрогдсон арга гэж хэлж болно. Эрсдлийн удирдлагын тогтолцоо нэвтрээгүй өнөөгийн нөхцөлд хилээр хууль бусаар нэвтрүүлэхийг оролдож буй оролдлого бүрийг таслан зогсоох боломжгүй. Нөгөө талаас ийм төрлийн гэмт хэргийг гол төлөв гэмт хэргийн бүлэглэлүүд үйлддэг, харгис хатуу ямар ч аргаар хамаагүй сүлжээгээ өргөтгөн тэлэхийг оролдож байдаг.

Олон улсын туршлагад тулгуурлан манай улсын зүгээс хар тамхитай тэмцэх тэмцлээ амжилтад хүргэхийн тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

- Хар тамхины хэрэглээ нийлүүлэлтийн талаар үндэсний хэмжээний судалгаа явуулж, үүндээ үндэслэн ха тамхитай тэмцэх үндэсний стратегийг боловсруулан, түүнд нийцсэн хууль эрхзүйн шинэчлэлийг хийх
- Хар тамхитай тэмцэх үндэсний хэмжээний бүтцийг бий болгож, энэ ажлыг нэг төвөөс удирдах. Ингэснээр цагдаа, гаалиас гадна тагнуул, мэргэжлийн хяналт, банк, эрүүл мэнд, боловсролын байгууллагуудын үйл ажиллагааг хар тамхитай тэмцэх чиглэлд нэгдсэн зохион байгуулалтад оруулах боломж үүснэ. Мөн ийм бүтцийг бий болгосноор энэ ажилд зарцуулах тусгай төсөвтэй болох, гэрч болон хохирогчийг хамгаалах зэрэг боломжууд бүрдэнэ.
- Хар тамхитай тэмцэхдээ урьдчилан сэргийлэх, донтсон иргэнийг эмчлэх, нийгэмшүүлэх, дахин хэрэглэх явдлыг нь таслан зогсоох чиглэлд онцгой ач холбогдол өгч, үүнд хөрөнгө мөнгөө төсөвлөх,

зарцуулах шаардлагатай.

- Хэрэглэгчийг олж илрүүлсэн нөхцөлд мөшгих аргаар нийлүүлэгч, хууль бусаар импортлогч, зохион байгуулалттай гэмт бүлэглэл, сүлжээг илрүүлэх тал дээр онцгойлон анхаарах шаардлагатай. Олон улсын туршлагаас үзэхэд хар тамхийг хэрэглэгч, борлуулагчид гэмт бүлэглэлийн дарамтад байх нь түгээмэл тул хэргийг илрүүлэхэд туслалцаа үзүүлэх нь бага байдаг.
- Хар тамхины хууль бус эргэлтэй тэмцэхээс гадна эрүүл мэндийн зориулалтаар эмнэлэгийн байгууллагуудад хэрэглэдэг хар тамхины найрлагатай эм бэлдмэл, сэтгэцэд нөлөөлөх бодисуудын хэрэглээнд бүрэн хяналт тавьж, импортоор орж ирсэн эм бэлдмэлийг хаана хэрэглэж байгааг бүртгэлжүүлэх шаардлагатай. Учир нь донтсон иргэд хууль бус худалдааг хязгаарласан нөхцөлд хууль ёсны эм бэлдмэлүүдийг орлуулан хэрэглэх нь бий.
- Хүүхэд залуучуудад зориулсан сургалт сурталчилгаа, контентуудыг хөгжүүлэхээс гадна бүтээмжтэй ажлын байруудыг бий болгож, залуус хөдөлмөр эрхлэх боломжийг бий болгох нь ийм төрлийн гэмт хэргээс сэргийлэх гол арга зам болно.
- Дээрх ажлуудыг эхлэхээс өмнө эхний ээлжинд яаралтайгаар гаалийн лабораториудыг хамгийн сүүлийн үеийн тоног төхөөрөмжөөр бүрэн шинэчлэх, ажилтнуудыг хар тамхитай тэмцэх тал дээр сургаж бэлтгэх, ур чадварыг нь дээшлүүлэх зэргээр хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн гаалийн хяналтыг боловсронгуй болгох тал дээр ажиллах нь чухал юм.

Дүгнэлт

Монгол улсад хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн хэрэглээ ба нийлүүлэлт өсөн нэмэгдэж байгааг гаалийн байгууллагын статистик мэдээлэл болон цагдаагийн байгууллагын хэрэг бүртгэлийн тоо баримтуудын аль алинаас нь харахад илэрхий байна.

Хил дамнасан хууль бус худалдаа бол хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх бодисын нийлүүлэлтийн цорын ганц эх сурвалж. Үүнийг амжилттай хянаж чадвал Монгол улс энэ тахлаас бүрэн салах боломжтой.

Өнөөгийн манай тогтолцоонд хил гаалийн байгууллага, цагдаагийн байгууллагын аль аль хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй байгаа учраас нийлүүлэлт ба хэрэглээ өсч байна. Энэ нь хар тамхитай тэмцэж буй манай улсын тэмцэл амжилт муутай, энэ чиглэлээр ажиллаж буй төрийн байгууллагуудын ажил хэргийн уялдаа холбоо сул, үйл ажиллагаа нь доголдолтой, төсөв хөрөнгөний хувьд дутагдалтай байгааг харуулж байна.

Хар тамхи бол нийгмийн тахал. Ялангуяа өсвөр үе, залуучуудын дунд хар тамхи, сэтгэгдэд нөлөөлөх эм бэлдмэлийн хэрэглээ их, өсөн нэмэгдэх хандлагатай байгаа нь аюулын харанга дэлдэж байна. Ийм төрлийн хэрэглээ нэгэнт эрчээ авсан нөхцөлд таслан зогсооход бэрхтэй болдог тул одооноос хар тамхитай тэмцэх тэмцэлд онцгойлон анхаарч, бидний өгүүлэлд дурдсан арга хэмжээнүүдийг яаралтай авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Ашигласан материал

- АНУ-ын Төрийн департаментын Олон улсын хар тамхины хууль сахиулах асуудал эрхэлсэн газар, А. (2022). *Олон улсын мансууруулах бодисын хяналт стратегийн тайлан*.
- ГЕГ. (2010-2022). *Гаалийн зөрчилтэй тэмцэх, хэрэг бүртгэх газрын тайлан*. УБ.
- ГЕГ. (2023 оны 05 01). *Гаалийн байгууллагын цахим хуудас*. <https://www.customs.gov.mn/>-ээс Гаргасан
- Д.Баярсайхан. (2021 он). “*Гаалийн холбогдолтой конвенцийн эмхтгэл*”. Улаанбаатар.
- ДГБ. (2023 оны 05 10). *Дэлхийн Гаалийн Байгууллагын албан ёсны веб хуудас*. www.wcoomd.org-ээс Гаргасан
- Европын холбоо. (2023 оны 04 04). *Европын хар тамхи, мансууруулах бодисын донтолтыг хянах төв*. https://www.emcdda.europa.eu/index_en/-ээс Гаргасан
- Норвегийн засгийн газар. (2023 оны 04 05). *Норвеги улсын хар тамхины тухай тайлан 2020*. https://www.emcdda.europa.eu/publications/country-drug-reports/2020/norway_en-ээс Гаргасан
- Норвегийн нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн. (2023 оны 05 04). . <https://www.fhi.no/en/>-ээс Гаргасан
- НҮБ. (2022). *Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны тайлан*. УБ.
- НҮБ. (2023 оны 05 12). *НҮБ-дэргэдэх мансууруулах бодис ба гэмт хэргийн асуудал эрхэлсэн албаны веб хуудас*. www.unodc.org-ээс Гаргасан
- Төрийн байгууллага, Н. (2023 оны 05 08). *Норвеги улсын хар тамхины тухай тайлан 2017*. https://www.emcdda.europa.eu/publications/country-drug-reports/2017/norway_en-ээс Гаргасан
- Төрийн департамент, А. (2023 оны 05 03). *2022 International Narcotics Control Strategy Report*. <https://www.state.gov/2022-international-narcotics-control-strategy-report/>-ээс Гаргасан
- Хууль зүйн үндэсний хүрээлэн. (2023 оны 05 13). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*. www.legalinfo.mn-ээс Гаргасан
- ЦЕГ. (2022). *Цагдаагийн ерөнхий газрын хар тамхитай тэмцэх газрын 2022 оны тайлан*. УБ.